



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 26

Өлгий

**Үер усны аюулд нэрвэгдсэн айл өрхүүдийг аврах,  
үерийн аюулаас сэрэмжлүүлэх арга хэмжээ авах тухай**

2018 оны 7 дугаар сарын 14-нөөс хойш үргэлжлэн орсон хүчтэй ширүүн борооны улмаас Өлгий сумын 2, 3, 4, 9, 11, 12, 13 дугаар багуудын 530 айл өрхийн 2512 хүн үерт автагдаад байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан үерийн гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг цаг алдалгүй зохион байгуулсан.

Одоогийн байдлаар уулын үерийн гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг давхардсан тоогоор 18 байгууллагын 551 алба хаагч, 87 нэгж техниктэйгээр тасралтгүй зохион байгуулж, нийт 449 иргэнийг аюулгүй газарт татан гаргаж, 630 иргэнийг Багшийн сургуулийн дотуур байр, 6 дугаар ахлах сургуулийн болон МСҮТ-ийн дотуур байр зарим цэцэрлэгүүд зэрэг түр хорогдох байранд байрлуулсан. Мөн 43 айлыг нүүлгэн шилжүүлж, 3.9 км үерийн хамгаалалтын далан босгож, хуримтлагдсан усыг зайлуулах шуудуу татсан ба үргэлжлүүлэн Хөвд голд цутгах ажлыг эхлүүлээ.

Түүнчлэн гамшгийн голомтод нэмэлтээр Баруун бүсийн 4 аймгийн Онцгой байдлын газрын 32 алба хаагч, 4 нэгж техниктэйгээр үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Бороо цаашид үргэлжлэн орох төлөвтэй тул үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, ард иргэдийг болзошгүй аюулаас хамгаалах, үерт нэрвэгдсэн иргэдийг аврах, түр байраар хангах, шинээр гарч болзошгүй хүндрэлээс хамгаалах зорилгоор дараах албан даалгаврыг хүргүүлж байна.

**Нэг. Сумын Засаг дарга, сумын онцгой комиссын дарга нарт даалгах нь:**

1. Сумын хэмжээнд гол горхины үерт автаж болзошгүй иргэдийг яаралтай нүүлгэн шилжүүлэх.
2. Сумдын онцгой комиссын бүрэлдэхүүнийг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу бэлэн байлгах.
3. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх
4. Цаг агаарын нөхцөл байдалтай холбоотой мэдээ мэдээллээр ард иргэдийг шуурхай хангах.
5. Өлгий сумын үерт нэрвэгдсэн 2, 3, 4, 9, 11, 12, 13 дугаар багийн Засаг дарга нарыг уртасгасан цагаар ажиллуулах

**00000015**

6. Өлгий сумын Засаг дарга түр хорогдох байранд байгаа иргэдийг халуун хоолоор хангах ажлыг зохион байгуулах

**Хоёр. Аймгийн Онцгой байдлын газар /С.Пүрэвсамдан/ -т даалгах нь:**

1. Уулын үер буусны улмаас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан эрэн хайх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шаардлагатай хүн хүч, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах
2. Үерт өртсөн айл өрхүүдийн хохирлын хэмжээг тогтоох ажлыг ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах
3. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг тогтмол, бүрэн бүрэлдэхүүнээр ажиллуулж бэлэн байлгах,

**Гурав. Эрүүл мэндийн газар /С.Айгүл/-т даалгах нь:**

1. Үерийн улмаас хохирол амссан иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эмчийн хяналтыг түр хорогдох байранд байнга ажиллуулах.
2. Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулан, үерт автсан ард иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх.
3. Үер буусан талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг зохион байгуулах.
4. Өлгий сумын үерт автсан багуудын харьяалалд байгаа жирэмсэн эх болон нярайн эрүүл мэндийн хяналтыг эрчимжүүлэх.
5. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийхэд шаардагдах бодис болон шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх

**Дөрөв. Мэргэжлийн хяналтын газар /Б.Мухамед/-т даалгах нь:**

1. Үер буусан талбайд хөрсний шинжилгээ хийж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх талбайн хэмжээг тогтоох.
2. Түр хорогдох байранд байрлаж буй иргэдийн хоол хүнс, эрүүл ахуйн байдалд тогтмол хяналт тавих

**Тав. НААҮ-ний "СУАТ" ХХК /Ж.Адалбек/-д даалгах нь:**

1. Өлгий сумын үерт автсан 2, 3, 4, 9, 11, 12, 13 дугаар багуудын ард иргэдийг цэвэр 'усаар хангах арга хэмжээ авах.
2. Гүний худаг болон цэвэр усны шугамын түгээлтийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах.

**Зургаа. Цахилгаан шугам сүлжээний газар /Ж.Керей/-т даалгах нь:**

1. Өлгий сумын үерт автсан 2, 3, 4, 9, 11, 12, 13 дугаар багуудын айл өрхүүдийн цахилгаан эрчим хүчний аюулгүй байдал, цахилгаан эрчим хүчээр хангах.
2. Үерт хохирол амсаж очих газаргүй болсон иргэдийн байрлаж буй байруудыг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах.

**Зургаа. Цагдаагийн газар /Б.Батхүү/-т даалгах нь:**

1. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан нийгмийн хэв журам сахих талаар арга хэмжээ авч ажиллах.
2. Иргэдийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний зохицуулалт, эмх замбараагүй байдал бий болохоос урьдчилан сэргийлж онц чухал объектуудыг хамгаалалтад авч ажиллах.
3. Хулгайн гэмт хэрэг гарч болзошгүй тул цагдаагийн эргүүл, гудамжны камеруудын байнгын ажиллагааг хангаж, хяналтыг эрчимжүүлэх

**Долоо. Зэвсэгт хүчний 340 дүгээр анги /Б.Дорждэрэм/,  
ХЦ-ийн 165 дугаар анги/Х.Гантулга/, "Жол" ХХК /Б.Көксеген/-д  
нарт даалгах нь:**

1. Үерт автсан айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхэд туулах чадвар сайтай авто техникээр хангаж ажиллах
2. Үерийн улмаас бий болсон шороо, хог хаягдлыг цэвэрлэх, хаагдсан замуудыг нээж, арчлах ажлыг гүйцэтгэх
3. Үерийн усыг Ховд голд цутгах шуудуу ухах, усыг зайлуулах ажилд дэмжлэг үзүүлж ажиллах.

**Найм. Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Х.Заур/,  
МСҮТ-ийн дарга /И.Жанболат/,  
Багшийн сургуулийн захирал /Киналган/ нарт даалгах нь:**

1. Үерт автан байшин нь нурж орон гэргүй болсон ард иргэдийг түр хорогдох байраар хангаж ажиллах.
2. Өлгий сумын цэцэрлэгүүдийн тогооч, туслах тогооч нарыг татан оролцуулж түр хорогдох байранд байрлаж буй иргэдийг халуун хоолоор хангах

**Ес. ОНРТ /Н.Оспан/ болон хэвлэл, мэдээллийн байгууллагуудад даалгах нь:**

1. Цагийн байдалтай холбоотой мэдээллийг үнэн бодитойгоор ард иргэдэд хүргэх.
2. Худал ташаа мэдээлэл нэвтрүүлж ард иргэдийн сэтгэл санааг үймүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

**Арав. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн  
газар /Г.Нансалмаа/ - т даалгах нь:**

1. Үерт нэрвэгдсэн өрхүүдийн хүүхдүүд тоо бүртгэлийг хөтөлж, хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээ авах
2. Иргэдийн сэтгэлийг засах арга хэмжээг зохион байгуулах

Арван нэг. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудад даалгах нь:

1. Гамшгийн тухай хуульд заасан үүргийн хүрээнд бүх талын ажил зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах
2. Албан байгууллагууд албан хаагчдаа шаардлагатай тохиолдолд холбогдох бүсэд дайчилан ажиллах бэлтгэлийг хангах

Арван хоёр. Улаан загалмайн нийгэмлэг/Х.Ертай/, ДЗМОУБ/Д.Болатбек/ - нарт даалгах нь:

1. Үерт нэрвэгдсэн айл өрхүүдийн судалгааг авч гадаад дотоодын донор байгууллагуудад танилцуулан хүмүүнлэгийн тусламж дэмжлэг үзүүлэх ажил зохион байгуулах
2. Иргэдийн сэтгэл санааг тогтворжуулах, тайвшруулах олон талт арга хэмжээ явуулах
3. Бусад төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэдийн хохирол амссан иргэдэд тусламжийн гараа сунгахад манлайлан үлгэр дуурайлал болж ажиллах.

Албан даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээ тайланг өдөр бүр Онцгой комисс болон Шуурхай штабт мэдээлж байхыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, ОБГ-ын дарга Пүрэвсамданд даалгасугай.

